



**ХАЛДВАРТ ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/71

Улаанбаатар хот

Ажлын байрны орчин нөхцөл,
нийгмийн асуудлыг дэмжин ажиллах тухай

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр батлах тухай” 193 дугаар тогтоол, Ковид-19-ийн халдвартай тэмцэж байгаа ажилчдын нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1.Төвийн ажилчдын ажлын байрны орчин нөхцөл, ажлын сэтгэл ханамжийг сайжруулах, ажлаас халшрах хам шинж, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, ажилчдад урам зориг өгөх, ажилчдын сэтгэл санааг дэмжих асуудалд үнэлгээ хийж, шийдэл гаргаж, гүйцэтгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

| | | |
|-----------------------|----------------|-----------------------------------------------|
| Ажлын хэсгийн ахлагч: | Н.Батням | Эдийн засагч |
| Гишүүд: | Б.Оюунтуяа | Мэдээлэл технологийн албаны дарга |
| | Д.Жаргалсайхан | Соёл үйлчилгээний албаны дарга |
| | Ж.Даваалхам | ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны дарга |
| | Ж.Баярсайхан | Сургалтын албаны дарга |
| | Б.Саруул | Амбулаторийн тасгийн эрхлэгч |
| | Ц.Батзаяа | Чанарын менежер |
| | А.Шинэхүү | Эдийн засагч |
| | Н.Норовжаргал | Сувилахуйн арга зүйч |
| | Б.Мягмарсүрэн | Зооноз бруцеллёзын тасгийн арга зүйч сувилагч |

2. Дээрхи асуудлуудын талаар үнэлгээ хийж, шийдэл гарган, төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйгээр ханган ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга (И.Орхон)-д үүрэг болгосугай.

4. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн ажилд зохих журмын дагуу зардал олгохыг Санхүү бүртгэлийн албаны дарга, Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Даваацэрэн)-д зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.БАТТӨР